

ОЙР ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛ СОНИН СЭТГҮҮЛИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ ТООЧИЛ

Оюун*

* Өвөр Монголын Их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн дэд профессор, докторант
Хөрвүүлсэн Л.Норовсүрэн

Түлхүүр үг: ойр орчин үе, монгол сонин сэтгүүл, судалгааны тойм тоочил.

Агуулгын товч: тус өгүүлэлд ойр орчин үеийн монгол сонин сэтгүүлийн судалгааны байдлыг улсын дотоод, гадаадад хэвлэгдсэн тусгай ном ба эрдэм шинжилгээний өгүүлэлд суурилан материалын чанартай судалгаа, түүхэн судалгаа, тусгай сэдвийн судалгаа хэмээн гурван зүйлд хуваан танилцуулжээ.

Монгол сонин сэтгүүлийн судалгаа бол хэвлэл мэдээллийн судалгааны бүрэлдэхүүн хэсэг болохоор барахгүй Монголын түүх соёлын судалгааны чухал бүрэлдэхүүн мөн.

Монгол сонин сэтгүүлийн судалгаа нь Монгол судлалын хүрээ царгаанд шинэхэн үүссэн шинжилгээний салаа болсны хувьд түүнийг монгол хэл, утга зохиолын судлалтай харьцуулбал эхлэлт оройхон, тархай бутархай, бүдүүвч байдалтай байсан боловч, хорь гаруй жилийн шинжилгээний бүтээн байгуулалт, жич судлал шинжлэлээр

дамжаад баярлууштай үр бүтээмж олсон юм.

Ойр орчин үеийн монгол сонин сэтгүүлийн судалгааны үр бүтээмжийг үндсэндээ гурван зүйлд төрөлжүүлж болно.

Нэг. Материалын чанартай судалгаа

Өвөр Монголын номын сангийн судлагч Түймэрийн “Улс байгуулагдахаас өмнөх Өвөр Монголын газар орны сонин сэтгүүлийг магадалсан гарчиг”-т 1949 оны 10-р сараас өмнө хэвлэгдсэн Өвөр Монголын сонин сэтгүүлийн хэвлэгдсэн цаг, эрхэлсэн хүн буюу байгууллага нэгж, хэдэн дугаар хэвлэгдсэн, сонин сэтгүүл эрхэлсэн зорилт, сонин сэтгүүлийн агуулга зэргийг танилцуулж, Монголын түүх соёл ба хэвлэл мэдээллийн судалгаанд чухал хэрэгцээ бүхий үндсэн материалыг гаргасан юм. Найман муж орны монгол хэл бичгийн ажлыг хамжилцах дугуйлангийн албан гэрийн найруулсан “Бүх улсын монгол хуучин ном бичгийн нэгтгэсэн гарчиг”-т орчин үеийн 27

монгол сонин сэтгүүлийн хэвлүүлэгч, түүний дугаар, жич эдгээрийн хадгалагдаж байгаа газрыг тодорхойлсон байна.

Дундад улсын эртний монгол ном бичгийн найруулах зөвлөлийн найруулсан “Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчиг”-т нэлээд тооны эртний монгол сонин сэтгүүлийн хадгалагдаж байгаа байдлыг танилцуулжээ.

Лигдэнгийн “Хорьдугаар зууны Дундад улсын монгол уран зохиолын сэтгүүлийн дээж бичиг”-т 1939-1960 он болтолх монгол сэтгүүл дээр нийтэлсэн уран зохиолыг сонгон хэвлэжээ. Монгол судлалын нэвтэрхий толийн найруулах комиссын сонин мэдээ, хэвлэлийн ботийн найруулах комиссын найруулсан “Монгол судлалын нэвтэрхий толь (Сонин мэдээ, хэвлэлийн боть)”-д ойр орчин үеийн сонин сэтгүүлийн тухай нэлээд бүрэн бүтэн материалыг хангажээ. Боржигон Мөнхдалайн найруулсан “Бээжингийн номын сангийн монгол хуучин бичгийн товч”-ид Бээжингийн номын санд хадгалагдаж байгаа 28 сонин сэтгүүлийг танилцуулжээ. Хөх хотын үндэсний явдлын комиссын найруулсан “Үндэсний хуучин бичиг хийгээд монгол соёл”-д “Сүй юан монгол үсгийн хагас сарын дармал” (1-15 дугаар), “Монгол утгын долоон өдрийн сэтгүүл” (1 дугаар), “Монгол газарч” (3, 6-7 дугаар)-ыг нийтлэхийн дагуу Түймэр гуайгаас нэн гурван дармалд дөхөм танилцуулга хийжээ. Д.Цэдэв, Вэн Мандаагийн найруулан зохиож, харгуулан зассан “Дотоод Монголын ардын сэтгүүлийн гэрэл зургийн буулгавар ариутгал шүүдэг”-т “Дотоод Монголын ардын сэтгүүл” (1-8 дэвтэр)-ийн гэрэл

зургийн буулгавар эх ба түүнийг ариутган шүүсэн засвар эхийг нийтэлсний хамт тус сэтгүүл хийгээд, сэтгүүл эрхлэгчийн тухай судалгааны өгүүллийг нийтэлсэн байна. Сонин буюу сонины үйлсийн ойллогод “Зарим аймгийн сонины үйлсийн ойллого”, “Ордосын өдрийн сонины хорооны ойллого”, “Шилийн голын өдрийн сонины ойллого”, “Өвөр Монголын өдрийн сонины тавин жил” хэвлэгдэж, эдгээр сонинуудын түүх гарлын тухай материал ойр орчин үеийн сонин сэтгүүлийн судалгаанд үндсэн материал хангажээ.

Хоёр. Түүхэн судалгаа

Ойр орчин үеийн монгол сонин сэтгүүлийн түүхэн судалгаанд сэтгүүлч, судлагч Г.Дэлэгийн “Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” нь монгол хэлээр гарч байсан анхны сонин сэтгүүлээс Монголын ардын засаг байгуулагдсан эхний жилд гарч байсан сонин сэтгүүлийн хөгжлийн түүхийг нийгэм зүйн талаас судалжээ. Өвөр Монголын их сургуулийн дэд профессор Төгсцогт нарын “Монгол сонин сэтгүүлийн түүхэн тойм” нь 1949 оноос өмнө гарч байсан хориод монгол сонин сэтгүүлийг нэлээд нарийн танилцуулан судалсан байдаг.

Монгол улсын их сургуулийн профессор Л.Норовсүрэн “Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм”-д монгол хэлээр гарч байсан анхны сонин сэтгүүлүүдээс эхлэлт авч Монгол улсын байгуулагдсан эхний жилүүд болтолх хэвлэл мэдээллийн түүхийг маш нарийн судлан шинжжээ. Төвийн үндэсний их сургуулийн профессор Бэй Рүн Шен-гийн “Дундад

улсын цөөхөн тоот үндэстний үсэг бичгийн сонин сэтгүүлийн түүхэн товч"-ид Дундад улсын цөөхөн тоот үндэстний үсэг бичгийн сонин сэтгүүлийн түүхийг бүх талаар үнэлэн танилцуулсны дотор монгол үндэстний сонин сэтгүүлийг чухал агуулга болгож бичсэн байдаг. Өвөр Монголын их сургуулийн лектор Бү Вэн-ий "Анхны монгол сонин сэтгүүл хийгээд түүний онцлог" хэмээх өгүүлэл бол 1895-1920 он болтолх монгол сонин сэтгүүлийн үүсэл хөгжлийн түүхэн байдлыг задлан шинжилж, хэвлэл дармалын хэвлүүлэгчээр нь төрөлжүүлэн судалсан байдаг. Мөн монгол улсын судлагч А.Дашням "Монгол ард улсын ном хэвлэлийн хураангуй товч түүх", Д.Даш "Монголын үнэн" гэх зэрэг бүтээлүүддээ монгол хэлээр гарч байсан анхны сонинууд хийгээд Монгол улсын ардын хувьсгалын эхэн үеийн зарим сонин сэтгүүлийн тухай дурдсан байдаг.

Гурав. Тусгай сэдвийн судалгаа

XX зууны хориод оноос хойш ойр орчин үеийн монгол сонин сэтгүүлийн тухай эрдэм шинжилгээний чанартай судалгааны эрчим явах тутам чангарч, ямар нэгэн сонин сэтгүүлийг тусгайлан судалсан буюу адил бус харагшаас судалсан тусгай сэдвийн судалгааны бүтээл улмаар олширч ирлээ.

1. Аль нэгэн сонин сэтгүүл буюу ямар нэгэн цаг үеийн сонин сэтгүүлийг тусгайлан судалсан бүтээлд Б.Сүхийн «Бөххишиг хийгээд "Улаан барс" сэтгүүлийн судлал», "Иргэн улсын үеийн хэдэн монгол сонин сэтгүүл", «Иргэн улсын эхний үеийн "Монгол ер үгийн сэтгүүл" хийгээд "Монгол утгын

сэтгүүл"», «Хуурмаг Манжийн монгол засгийн журганы анхдагч ерөнхийлсөн чанартай сарын сэтгүүл "Монгол сэтгүүл"», «Хуурмаг Манжийн Монголын хязгаарын үеийн "Утга соёлын тусгай дармал" хийгээд "Монгол соёл"», "Ховор нандин түүхийн дурсгалт зүйлс", "Дотоод Монголын ардын сэтгүүл", "Ниффанд бүхий монголчуудын гарлын гурван дармал", "Монгол сурлагын хороо байгуулагдсан ойг тэмдэглэх тусгай дармалын сурвалж бичгийн үнэ өртөг", «"Монгол төвдийн долоон өдрийн сэтгүүл" хийгээд "Монгол төвдийн арван өдрийн сэтгүүл"-ийг ялган шинжлэх нь», «Жанчхүү дэх "Монгол утгын долоон өдрийн сэтгүүл"», «Орхигдсоор байгаад охь нь үлдсэн "Зүүн хойтох монгол хошуудын багшийн сургуулийн дармал"» зэрэг өгүүлэл нь дорвитой бүтээл болсон байдаг.

Үүнээс гадна Өвөр Монголын их сургуулийн дэд профессор Цогтын «Гүнсээноров хийгээд "Монгол ер үгийн сэтгүүл"», Өвөр Монголын их сургуулийн профессор Чойролжавын «"Монгол утгын сэтгүүл"-ийн нөхвөр магадлал», Өвөр Монголын их сургуулийн профессор Жин Хайгийн "Япон эзэлж байсан үеийн монгол үндэсний хэвлэл мэдээллийн ажиллагааны тойм тоочил", Өвөр Монголын их сургуулийн профессор Тайвангийн «"Шинэ монгол" хийгээд "Мандах монгол"-ын тухай», Токиогийн гадаад хэлний их сургуулийн профессор Путаки Хироши-гийн "Монголын хязгаарын засгийн үеийн монгол тогтмол хэвлэлийн тухай", Монгол улсын их сургуулийн профессор Л.Норовсүрэн-гийн "Ж.Цэвээн Монголын ууган сэтгүүлч

мөн”, “Мүгдэнгийн монгол сэтгүүлийн тухай”, Монгол улсын “Соёл эрдэм” дээд сургуулийн багш, докторант Н.Ариун-заяагийн «“Хөх туг”-ийн тухай хэдэн үг» гэх зэргийн өгүүллүүд бий.

2. Нийгэм-улс төрийн харагшаас шинжилсэн өгүүлэлд Японы Сиюүвэ эмэгтэйчүүдийн их сургуулийн лектор Хүсэлийн “1945-1947 оны хоорондох Өвөр Монгол оронд гарч байсан тогтмол хэвлэлийн шинжлэл – Өвөр Монголыг нэгтгэх хөдөлгөөнөөс Өвөр Монголын өөртөө засах засгийн ордон байгуулагдах бэлдэлгэ түүхийн тэмдэглэл”, Хиругава Саху-гийн «XX зууны дөчөөд он дахь Японы Өвөр Монгол дахь төрийн бодлого хийгээд “Хөх туг” сонин» зэрэг буй.

3. Хэл шинжлэлийн үүднээс шинжилсэн бүтээлд Японы Сиюүвэ эмэгтэйчүүдийн их сургуульд ажиллаж байгаа профессор Хөхбаатараас өөрийн доктор цол хамгаалах өгүүлэл “Дундад улсад хэвлэгдсэн монгол тогтмол хэвлэлийн хөгжилтийн түүхээс хятад хэлний нөлөөн дэх монгол хэлний орчин үеийн үгсийн бүрэлдлийг ажиглах нь” гэдэгт Дундад улсын ойр орчин үеийн тогтмол хэвлэлийн хэвлэгдсэн түүхэн ахуй байдлыг судалсаны хамт эдгээр сэтгүүлд гарсан үгсийн санг орчин үеийн монгол хэлэнд хадгалагдаж байгаа байдлыг харьцуула-

хаар дамжиж ойр орчин үеийн монгол хэлний үгсийн сангийн бүрэлдлийг судалжээ.

Профессор Хөхбаатар гуай бас Сиюүвэ эмэгтэйчүүдийн их сургуулийн орчин үеийн соёл судлах газрын “Гакуйен” сэтгүүлд нийтэлсэн цуврал өгүүлэл “Монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн бүрэлдлийн эх – “Монгол үгийн бодорол” (нэг) – хятад хэлнээс

шууд орчуулахаас эхэлсэн монгол хэлний үгсийн сангийн одоочилолт” “Монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн бүрэлдлийн эх – “Монгол үгийн бодорол” (гурав) – Гирингийн монгол үгийн бодоролын гарчгийн монгол үгсийн буулгалт (доорд)”, “Монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн бүрэлдлийн эх – “Мон-

«

Монгол сонин сэтгүүлийн судалгаа нь Монгол судлалын хүрээ царгаанд шинэхэн үүссэн шинэжилгээний салаа болсны хувьд түүнийг монгол хэл, утга зохиолын судлалтай харьцуулбал эхлэлт оройхон, тархай бутархай, бүдүүвч байдалтай байсан боловч, хорь гаруй жилийн шинэжилгээний бүтээн байгуулалт, жич судлал шинэжлэлээр дамжаад баярлууштай үр бүтээмж олсон юм.

»

гол үгийн бодорол” (дөрөв) – Өвөр Монголын өөртөө засах орны номын сангийн хадгалалтад байх хоёр дэвтэр “Монгол үгийн бодорол” ба Гирин мужийн дансан хадгалалтад байх “Монгол үгийн бодорол” сэтгүүл”, “Монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн сонголт, ангиллаар түүний оршил, устлын цаг үеийг шинжлэх нь”-д тусгайлан “Монгол үгийн бодорол” сэтгүүлийн үгсийн санг ширвэн шүүж, монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн бүрэлдлийн эх үүслийг шинжилсэн байна.

4. Уран зохиолын харагшаас судалсан бүтээл: Өвөр Монголын их сургуулийн профессор Б.Гэрэлтийн “Сугын ногоо” (Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1998 он)-нд 1931-1945 онд хэвлэгдэж байсан “Монгол шинэ сэтгүүл”, “Хүүхдийн шинэ сэтгүүл”, “Хөх туг”, “Улаан барс”, “Их хөх туг” зэрэг монгол сонин сэтгүүлд нийтлэгдэж байсан Эрдэмтөгс, Жинлиян, Баясгалан, Нямаа, Өргөнжав, Эрдэмбаатар, Хомог, Дэчингаа, Эрхэм, Пүлингaa зэрэг далаад шүлэгч, зохиогчийн 132 зохиол бүтээлийг уран зохиолын судалгааны харагшаас зохиогчтой нь хамт танилцуулан үнэлсэн байна.

5. Онолын талаас жам хууль, онцлог шинжийг хураангуйлан судалсан зүйлд Өвөр Монголын өдрийн сонины хорооны судлагч Багана гуай түрүүнд алхаж буй. Түүний “Сонин мэдээний түүхэн судлалын хүрээн дэх авралтын чанартай нэгэн чухал үүрэг”, “Монгол үндэсний ойр орчин үеийн сонин сэтгүүлийн анхны шинжлэл”, “Монгол үндэстний ойр орчин үеийн сонины үйлсийн хөгжилтийн явц”, “Дундад улсын монгол сонины үйлс болон түүний судлал” нөлөө ихтэй байжээ. Зарим нь шилдэг өгүүллээр шилэгдсэн байдаг.

Үүнээс гадна Өвөр Монголын их сургуулийн дэд профессор Цогтын “Ойр үеийн монгол сонин сэтгүүлийн онцлогийг задлах нь”, “Монгол сонин сэтгүүлийн түүхэн судалгаандахь хэдэн асуудлын тухай”, Өвөр Монголын их сургуулийн лектор Бү Вэний “Монгол сонин сэтгүүлийн үүсэл хөгжлийн шалтгаан” зэрэг өгүүллийг дурдаж болно.

Ерөнхийлбөл ойр орчин үеийн монгол сонин сэтгүүлийн судалгаа ХХ зууны тавь, жараад оноос түүхэн судалгаагаар эхлэлт авч, дал наяд оноос материалын чанартай судалгаагаар дорвитой явагдаж, ерээд оноос хойш эрдэм шинжилгээний чанартай судалгааны эрчим чангарч, эрдэм шинжилгээний бүтээл олшрон гүнзгийрч буй. Монгол сонин сэтгүүлийн судалгааны бүтээлийг хэрэглэсэн үсэг бичгээр нь үзвэл монгол, хятад, япон, англи хэлний байгаа мөртөө агуулгын талаас ажиглавал адил бусын харагшаас өгүүлэн задалж, үнэлэн танилцуулсан бүтээл мөн үй олон цолгорч, судалгааны хүрээ цараа улмаар өргөжин тэлэх хандаш илэрч буй.

Зүүлт

1. Т ү й м э р. 1987. Улс байгуулагдахаас өмнөх Өвөр Монголын газар орны сонин сэтгүүлийг магадалсан гарчиг. Хятад хэвлэл. Хөх хот.
2. 1979. Найман муж орны монгол хэлбичгийн ажлын хамжилцах дугуйлангийн албан гэр найруулав. “Бүх улсын монгол хуучин ном бичгийн нэгтгэсэн гарчиг”. Монгол хэвлэл. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
3. 1999. Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчиг. Монгол хэвлэл. Бээжин номын сангийн хэвлэлийн хороо.
4. Л и г д э н. 1999. Хорьдугаар зууны Дундад улсын монгол уран зохиолын сэтгүүлийн дээж бичиг. Нэгдүгээр дэвтэр. Үндэстний хэвлэлийн хороо.
5. 2003. Сонин мэдээ, хэвлэлийн боть найруулах комисс найруулав. “Монгол судлалын нэвтэрхий толь”. (Сонин мэдээ, хэвлэлийн боть). Монгол хэвлэл. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
6. 1989. Боржигон Мөнхдалай найруулав. “Бээжингийн номын сангийн монгол

- хуучин бичгийн товч". Монгол хэвлэл. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
7. 2006. Хөх хотын үндэстний явдлын комисс найруулав. "Үндэстний хуучин бичиг хийгээд монгол соёл". Монгол хэвлэл. 9 дүгээр хугацаа. Дотоод материал.
8. Цэдэв Д., Вэн Мандаа. 2007. "Дотоод Монголын ардын сэтгүүл"-ийн гэрэл зургийн буулгавар ариутгал шүүдэг". Монгол хэвлэл. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
9. Зарим аймгийн сонины үйлсийн ойллого. Найруулах комисс найруулав. "Зарим аймгийн сонины үйлсийн ойллого". Хятад хэвлэл.
10. 1996. Ордосын өдрийн сонины хорооны ойллого. Найруулах комисс найруулав. "Ордосын өдрийн сонины хорооны ойллого. Хятад хэвлэл. Дотоод материал.
11. 1997. Шилийн голын өдрийн сонины ойллого. Найруулах комисс найруулав. "Шилийн голын өдрийн сонины ойллого". Монгол хэвлэл. Дотоод материал.
12. 1998. Өвөр Монголын өдрийн сонины тавин жил. Найруулах комисс найруулав. "Өвөрмонголын өдрийн сонины тавин жил". Монгол хэвлэл. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.
13. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. Кирил үсэг. Улаанбаатар.
14. Төгсцогт нар. 1999. Монгол сонин сэтгүүлийн түүхэн тойм. Монгол хэвлэл. Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо.
15. Норовсүрэн Л. 2000, 2001, 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Гурван боть. Кирил үсэг. Улаанбаатар.
16. Бэй Рүн Шен. 1994. Дундад улсын цөөхөн тоот үндэстний үсэг бичгийн сонин сэтгүүлийн түүхэн товч. Хятад хэвлэл. Төвийн үндэстний их сургуулийн хэвлэлийн хороо.
17. Бү Вэн. 2004. Анхны монгол сонин сэтгүүл хийгээд түүний онцлог. Хятад үсэг. Мастер цол хамгаалах өгүүлэл.
18. Сүхээ Б. 2003. Бөххишиг хийгээд (Улаан барс) сэтгүүлийн судлал. Монгол хэвлэл. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.
19. Түймэр. Монгол үгийн бодоролын судлал (Монгол судлалын мэдээ занги) 2001 оны гуравдугаар хугацаа.
20. Түймэр. Иргэн улсын үеийн хятад, монгол хуучин сонин сэтгүүл. (Монгол судлалын мэдээ занги). 2002 оны 3 дугаар хугацаа.
21. Түймэр. Иргэн улсын эхний үеийн "Монгол ер үгийн сэтгүүл" хийгээд "Монгол утгын сэтгүүл". Өвөрмонголын Багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2002 оны 3 дугаар хугацаа.
22. Түймэр. Хуурмаг манжийн монгол засгийн журганы анхдагч ерөнхийлсөн чанартай сарын сэтгүүл. "Монгол сэтгүүл" (Монгол судлалын мэдээ занги). 2002 оны 2 дугаар хугацаа.
23. Түймэр. Хуурмаг манжийн монголын хязгаарын үеийн утга соёлын тусгай дармал хийгээд монгол соёл. (Монгол судлалын мэдээ занги). 2004 оны 1 дүгээр хугацаа.
24. Түймэр. Ховор нандин түүхийн дурсгалт зүйлс – "Дотоод Монголын ардын сэтгүүл". Өвөр Монголын номын сангийн ажил. 1986 оны 4 дүгээр хугацаа.
25. Түймэр. Монголчуудын Японд суралцагсдын нийгэмлэгийн гурван дармал. (Сонин мэдээний судлал). 1999 оны 1 дүгээр хугацаа.
26. Түймэр. Монгол сурлагын хороо байгуулагдсан ойг тэмдэглэх тусгай дармалын сурвалж бичгийн үнэ өртөг. (Өвөр Монголын орон нутгийн ойллого). 1994 оны 2 дугаар хугацаа.
27. Түймэр. "Монголын Төвдийн долоон өдрийн сэтгүүл" хийгээд "Монгол Төвдийн арван өдрийн сэтгүүл"-ийг ялган шинжлэх нь. (Сонин мэдээний судлал). 1998 оны 4 дүгээр хугацаа.
28. Түймэр. Жанчхүү дэх Монгол утгын долоон өдрийн сэтгүүл. 1994 оны 4 дүгээр хугацаа.
29. Түймэр. Орхигдсоор байгаад охь нь үлдсэн зүүн хойтох монгол хошуудын багшийн сургуулийн дармал. (Монгол судлалын мэдээ занги). 2004 оны 2 дугаар хугацаа.
30. Цогт. Гүнсээноров хийгээд "Монгол ер үгийн сэтгүүл". (Өвөр Монголын

нийгмийн шинжлэх ухаан). 1991 оны 5 дугаар хугацаа.

31. Ч о й р о л ж а в. Монгол утгын сэтгүүлийн нөхвөр магадлал. (Өвөр Монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл). 2006 оны 2 дугаар хугацаа.

32. Ж и н Х а й. Япон эзэлж байсан үеийн Монгол үндэстний хэвлэл мэдээллийн ажиллагааны тойм тоочил. (Төвийн үндэстний их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл). 2008 оны 4 дүгээр хугацаа.

33. Т а й в а н. 2005. "Шинэ Монгол" хийгээд "Мандах Монгол"-ын тухай. (Өвөр Монголын их сургуулийн анхдагч удааны хэвлэл мэдээллийн судлан ярилцах хуралд дэвшүүлсэн өгүүлэл).

34. П у т а к и Х и р о ш и. 2001. Монгол хязгаарын засгийн үеийн монгол тогтмол хэвлэлийн тухай. Япон хэл. (Японы монгол судлалын хурлын тэмдэглэл). №31.

35. Н о р о в с ү р э н Л. 2005. Ж. Цэвээн — Монголын ууган сэтгүүлч мөн. Өвөр Монголын Их Сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. №248.

36. Н о р о в с ү р э н Л. "Мүгдэнгийн монгол сэтгүүл"-ийн тухайд. МУИС-ийн "Сэтгүүл зүй" ЭШБ. №268(6).

37. А р и у н з а я а Н. "Хөх туг"-ийн тухай хэдэн үг. МУИС-ийн "Сэтгүүл зүй" ЭШБ. №293 (8). 2008.

38. Х ү с э л. 1945-1947 оны хооронд Өвөр Монгол оронд гарч байсан тогтмол хэвлэлийн шинжлэл — Өвөр Монголыг нэгтгэх хөдөлгөөнөөс Өвөр Монголын өөртөө засах засгийн ордон байгуулагдах болтолх түүхийн тэмдэглэл. Япон хэл. Токио Их сургуулийн "Хэл, газар орны соёлын судлал". №10.

39. Х и р у г а в а С а х у. 1998. ХХ зууны дөчөөд он дахь Японы Өвөрмонгол дахь төрийн бодлого хийгээд (Хөх туг) сонин. Япон хэл. Японы монгол судлалын хурлын тэмдэглэл. №28.

40. Х ө х б а а т а р. 1997. Дундад улсад хэвлэгдсэн монгол тогтмол хэвлэлийн хөгжилтийн түүхээс хятад хэлний нөлөөн дэх монгол хэлний орчин үеийн үгсийн бүрэлдлийг ажиглах нь. Доктор цол хамгаалах өгүүлэл.

41. Х ө х б а а т а р. Монгол хэлний орчин үеийн сангийн бүрэлдлийн эх (Монгол үгийн бодорол), (Нэг)-хятад хэлнээс шууд орчуулахаас эхэлсэн монгол хэлний үгсийн сангийн одоохчиллолт. Япон хэл. "Гакуян" сэтгүүлийн 775 дугаар.

42. Х ө х б а а т а р. Монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн бүрэлдлийн эх (Монгол үгийн бодорол). (Хоёр)-Гириний монгол үгийн бодоролын гарчгийн монгол үгсийн буулгалт (дээд). Япон хэл. "Гакуян" сэтгүүлийн 779 дүгээр.

43. Х ө х б а а т а р. Монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн бүрэлдлийн эх (Монгол үгийн бодорол). (Гурав)-Гириний монгол үгийн бодоролын гарчгийн монгол үгсийн буулгалт (Доорд). Япон хэл. "Гакуян" сэтгүүлийн 780 дугаар.

44. Х ө х б а а т а р. Монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн бүрэлдлийн эх (Монгол үгийн бодорол). (Дөрөв)-Өвөр Монголын өөртөө засах орны номын сангийн хадгалалтад байх хоёр дэвтэр (Монгол үгийн бодорол) ба Гирин мужийн дансан эвхмэлийн газрын хадгалалтад байх (Монгол үгийн бодорол) сэтгүүл. Япон хэл. "Гакуян" сэтгүүлийн 781 дугаар.

45. Х ө х б а а т а р. Монгол хэлний орчин үеийн үгсийн сангийн бүрэлдлийн эх (Монгол үгийн бодорол). (Тав)- орчин үеийн үгийн сангийн сонголт, ангиллаар түүний оршил, устлын цаг үеийг шинжлэх нь. Япон хэл. "Гакуян" сэтгүүлийн 787 дугаар.

46. Г э р э л т Б. 1998. Сугын ногоо. Монгол хэвлэл. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

47. Б а г а н а. 1997. Сонин мэдээний түүхэн судлалын хүрээн дэх авралтын чанартай нэгэн чухал үүрэг. (Сонин мэдээний судлал). Хэвлэл сэргэсэн дугаар.

48. Б а г а н а. Монгол үндэстний ойр орчин үеийн сонин мэдээллийн анхны шинжлэл. Өвөр Монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2004 оны 6 дугаар хугацаа.

49. Б а г а н а. Монгол үндэстний ойр орчин үеийн сонины үйлсийн хөгжилтийн явц. Өвөр Монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2004 оны 3 дугаар хугацаа.

50. Багана, 2003. Дундад улсын монгол сонины үйлсийн болон түүхийн судлал. (Монгол судлалын нэвтэрхий толь. Сонин мэдээ, хэвлэлийн боть). Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

51. Цогт. Ойр орчин үеийн монгол сонин сэтгүүлийн онцлогийг задлах нь. Өвөр Монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2001 оны 1 дүгээр хугацаа.

52. Цогт. Монгол сонин сэтгүүлийн түүхэн судалгаан дахь хэдэн асуудлын тухай. Өвөр Монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2001 оны 4 дүгээр хугацаа.

53. БүВэн. Монгол сонин сэтгүүлийн үүсэл хөгжлийн шалтгаан. Өвөр Монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2004 оны 2 дугаар хугацаа.

Резюме

В настоящей статье автор даёт краткий обзор исследовательским работам, посвящённым периодической печати на монгольском языке. Опираясь на работы монгольских, китайских и японских учёных, вышедших в КНР и за рубежом, автор предлагает следующую классификацию: исследование собственно газет и журналов, историческое исследование и исследование специальной тематики. Как считает автор, начало исследовательских работ, посвящённых истории функционирования периодики на монгольском языке, было положено в 1950-1960-х гг., 1970-80-е гг. озаменовались их бурным ростом, последнее же десятилетие прошлого века, начало нынешнего стало периодом специализации и конкретизации работ.